- ✓ Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнтэй тулган баталгаажуулахад 500,000.00 төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.
- ✓ Мөнгөн гүйлгээний тайлан дах биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг Үндсэн хөрөнгийн тайлангийн худалдан авсан хөрөнгийг тулган баталгаажуулахад 692,622,244.69 төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.
- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайланд Гэрэл, цахилгааны зардлыг 1,337,379.85 төгрөгөөр дутуу, Түлш халаалтын зардлыг 864,387.62 төгрөгөөр илүү, Цэвэр, бохир усны зардлыг 39,997.00 төгрөгөөр дутуу, Бичиг хэргийн зардлыг 1,299,100.00 төгрөгөөр илүү, Тээвэр, шатахууны зардлыг 282,103,190.43 төгрөгөөр илүү, Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгалын зардлыг 1,285,284.00 төгрөгөөр илүү, Томилолт, зочны зардлыг 56,000.00 төгрөгөөр илүү, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 649,844,227.48 төгрөгөөр дутуу, Бараа үйлчилгээний бусад зардлыг 13,921,700.00 төгрөгөөр дутуу, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 1,880,600.00 төгрөгөөр дутуу, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардал 6,286,000.00 төгрөгөөр дутуу, Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 1,000,000.00 төгрөгөөр илүү тус тус илэрхийлсэн байна.
- ✓ Санхүүгийн тодруулгын өглөгийн тайланд Цалингийн өглөгийг 17,353,246.00 төгрөг, гэрэл цахилгааны өглөгийг 2,664,643.19 төгрөг, Түлш халаалтын өглөгийг 3,590,697.00 төгрөг, Шуудан холбооны өглөгийг 1,717,850.00 төгрөг, Цэвэр, бохир усны өглөгийг 400,953.00 төгрөг, Тээвэр шатахууны өглөгийг 4,514,300.00 төгрөг, Албан томилолтын өглөгийг 3,924,000.00 төгрөг, Урсгал засварын өглөгийг 28,436,600.00 төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасан байна.

Аудитаар нийт 190,179.3 мянган төгрөгийн зөрчил¹⁵ илэрснээс 89,000.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлж, 98,934.3 мянган төгрөгийн 10 зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлага, 2,245.0 мянган төлбөрийн 1 зөрчилд акт тогтоож ажилласан байна.

ТӨЛБӨРИЙН АКТ:

- **Илрүүлэлт:1** Бичиг хэргийн эрхлэгч нь ээлжийн амралтын цалингаа 8 сард тооцуулан авсан боловч Архив бичиг хэргийн эрхлэгчийг ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй үндэслэлээр 1,815,000 төгрөгийг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох захирамж гараагүй байхад 1 албан хаагчид 430,000 төгрөгийн зэрэг дэв олгосон байна.
- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

- **Өгсөн төлбөрийн акт-1:** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу төлбөрийн акт тогтоох

5.2 АЛБАН ШААРДЛАГА: Санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- **Илрүүлэлт:1** Хагас, бүтэн жилээр 11,366,510,274.97 төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байгаа нь төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хяналт алдагдсан байх эрсдэлийг үүсгэсэн байна.
- Энэ нь УСНББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллого заавал хийнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.
- **Өгсөн албан шаардлага:1** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3 "Хууль тогтоож, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасны дагуу албан шаардлага хүргүүлэх
- **Илрүүлэлт:2** Он дамжсан 24,296,300.00 төгрөгийн өвсний авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, мөн барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.
- Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" дахь заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.
- **Өгсөн албан шаардлага:2** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх
- **Илрүүлэлт:3** Албан хаагчдын алба хаасан хугацааны нэмэгдэл, зэргийн нэмэгдлийг түүвэрлэн шалгахад хувь хэмжээ сар бүр өөрчилж олгосон байна.
- Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.
- **Өгсөн албан шаардлага:3** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх
- **Илрүүлэлт:4** Шатахууны зарцуулалтыг түүвэрлэн шалгахад хувийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг албан хэрэгцээнд унахдаа жолоочийн тооцооны хуудсыг дутуу бөглөсөн,спидометрийн заалт бичээгүй, шаардах хуудсыг бүрэн бөглөөгүй, шатахууны норм, норматив тооцоогүй, авто машин унах эрхгүй албан тушаалтнуудад хяналтгүй тээврийн хэрэгсэл ашиглаж, шатахуун зарцуулсан байна.
- Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.21-д "нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн болон аймгийн Засаг даргын тамгын газар, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын тамгын газар", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар "Жишиг норм батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралт, 2 дугаар хавсралт, 3 дугаар хавсралт-д заасантай тус тус нийцэхгүй байна.
- **Өгсөн албан шаардлага:4** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

- **Илрүүлэлт:5** Бага үнэтэй, түргэн элэгдэх /210406/ зардлаас 2,858,100.00 төгрөгийн хүнсний бараа, 70,000.00 төгрөгөөр бууз, хуушуур, 113,000.00 төгрөгөөр тахианы махтай пицца, хонины махтай бууз, 380,000.00 төгрөгийн принтер, 650,000.00 төгрөгийн сандал, Багаж, техник хэрэгсэл /210601/ зардлаас 135,000.00 төгрөгийн суурин утасны төлбөр, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх /210902/ зардлаас 385,500.00 төгрөгийн 100 жилийн ойн арга хэмжээний хамт олны зураг, Шуудан, холбоо, интернэт /210403/ зардлаас 300,000.00 төгрөгийн нэгж худалдан авч төсвийн хөрөнгийг зарцуулсан байна
- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"-д заасантай нийцэхгүй байна
- **Өгсөн албан шаардлага:5** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

- **Илрүүлэлт:6** Тайлант хугацаанд 1203-ӨМЭ улсын дугаартай Ланд-200 тээврийн хэрэгсэлд 5,516,500.00 төгрөг, 6177-ӨМА улсын дугаартай фургонд 4,649,900.00 төгрөгөөр урсгал засвар хийхдээ техник ашиглалтын паспорт хөтлөөгүй байна.
- Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-д "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна"-д заасантай тус тус нийцэхгүй байна.
- **Өгсөн албан шаардлага:6** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

- **Илрүүлэлт:7** Засаг даргын Тамгын газрын багийн дарга нарын хувийн эзэмшлийн 1142-ӨМЭ дугаартай Pguis-30 маркийн авто тээврийн хэрэгсэлд 485,000.00 төгрөгийн урсгал засвар, 2272-ӨМӨ улсы дугаартай Pguis-30 маркийн хувийн хэрэгцээний авто тээврийн хэрэгсэлд 680,900.00 төгрөгийн урсгал засвар, 7225-ӨМӨ улсын дугаартай Recton маркийн авто тээврийн хэрэгсэлд 286,000.00 төгрөгийн аккумулятор, 5043-ӨМЭ улсын дугаартай Toyota Sai маркийн авто тээврийн хэрэгсэлд 560,000.00 төгрөгөөр тус тус урсгал засвар хийж төсвийн хөрөнгийг зарцуулсан байна
- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"-д заасантай нийцэхгүй байна.
- **Өгсөн албан шаардлага:7** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

- **Илрүүлэлт:8** Баг, хорооны үйл ажиллагааны /210801/ зардлаас Багийн иргэдийн нийтийн хурлаар багийн төвийг цэвэрлэх, гадна талбайн хог цэвэрлэх, шатаах зэрэг ажлыг хариуцаж ажиллуулахаар 4 багийн иргэнтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан улиралд 660,000.00 төгрөгөөр ажлын хөлсийг тооцож олгосон боловч гүйцэтгэсэн ажил нь баримтаар нотлогдохгүй төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.
- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"-д заасантай нийцэхгүй байна.
- **Өгсөн албан шаардлага:8** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

- **Илрүүлэлт:9** Ханхонгор сумын 100 жилийн ойн бэлтгэл арга хэмжээнд 5 болон 6 ханатай гэр нийлүүлэх ажлын Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон

холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулаагүй, баримт бичгийн бүрдэл дутуу, цахим системд нийтлээгүй байна.

- Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална", 11.2-т "Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана"-д заасантай тус тус нийцэхгүй байна.
- **Өгсөн албан шаардлага:9** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх
- **Илрүүлэлт:10** Ажлын байрны албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан зорилттой давхардуулан Засаг даргын Тамгын газрын няравтай "Сумын төвийн ногоон байгууламж усалж арчлах" ажлын гэрээ байгуулан 1,000,000 төгрөг олгосон байна.
- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 15 дугаар зүйлийн 15.1.2-д "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох"-д заасантай тус тус нийцэхгүй байна.
- **Өгсөн албан шаардлага:10** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

5.3 ЗӨВЛӨМЖ:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

- **Илрүүлэлт:1** Засаг Даргын Тамгын газрын даргын 2024 оны А/01 дугаар тушаалын албан хаагчдын цалин, нэмэгдлийн хэмжээ хүний нөөцийн мэдээлэлтэй зөрүүтэй, төсөв захирагч өөрт олгогдсон бүрэн эрхийг үндэслэж тушаал гаргаагүй байна.
- Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- **Өгсөн зөвлөмж-1:** Тушаал шийдвэр, хөдөлмөрийн гэрээг хуулийн хүрээнд үнэн зөв боловсруулж, хэрэгжилтийг хянаж ажиллах зөвлөмж хүргүүлэх
- **Илрүүлэлт-2:** Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг НХМаягт БМ-8 маягт, бараа материалын тайланг НХМаягт БМ-9 маягтаар хөтлөөгүй, шаардах хуудас бөглөөгүй, 587,121,605.90 төгрөгийн бараа материалыг тооллогоор баталгаажуулаагүй, үлдэгдлээр тайлагнан эргэлтийн хөрөнгө дутагдах эрсдэлийг үүсгэсэн байна

- Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-д "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдээдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх", 72 дугаар зүйлийн 72.1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 8-д /... хөрөнгийн тооллогын бүртгэлд байгууллагын нэр, эд хөрөнгийн нэр төрөл, хаана ашиглагдаж байгаа, хөрөнгийн чанар байдал зэргийг тэмдэглэхийн хамт тооллогын бүртгэлийн хуудас бүрийн ард тооллогын комиссын дарга, гишүүд, эд хариуцагч гарын үсэг зурна/-д заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- **Өгсөн зөвлөмж-2:** Эргэлтийн хөрөнгийн тооллогыг тухай бүр холбогдох журмын дагуу чанартай гүйцэтгэж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг арилгаж ажиллах зөвлөмж хүргүүлэх
- **Илрүүлэлт-3:** "Ёл мухар шивэртийн амны мөс нэмэгдүүлэх арга хэмжээний ажил"-ыг 5,000,000 төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч хийсэн ажлын тайлан байхгүй, гэрээнд хийх ажлыг тодорхой тусгаагүй байна.
- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын 3.1.Төсөл, арга хэмжээний төлөвлөлт: 3.1.4.5-д "холбогдох баримт материал, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
- **Өгсөн зөвлөмж-3:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх
- **Илрүүлэлт-4:** Тус байгууллагад бүртгэлтэй 1203-ӨМЭ улсын дугаартай 84,000,000 төгрөгийн дансны үнэтэй Ланд-200 маркийн тээврийн хэрэгслийг 2024 оны 08 сард үерт автуулсан гэх шалтгаанаар ашиглах боломжгүй байгаад мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй байна.
- Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2.1.7-д "ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдээдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- **Өгсөн зөвлөмж-4:** Тээврийн хэрэгслийн ашиглалтад мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмж хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|-----------|-----------------------------------|-----|--------------------------|-----------|------------|-----------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн орлогын дүнг Нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн дүнтэй тулган баталгаажуулахад 310,814,407.21 төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна. | 1 | 310,814.4 | | | 1 | 310,814.4 | 1 | 310,814.4 | | | | |
| Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хассан дүнг Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээтэй тулган баталгаажуулахад 312,099,407.21 төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна. | 1 | 312,099.4 | | | 1 | 312,099.4 | 1 | 312,099.4 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнтэй тулган баталгаажуулахад 500,000.00 төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна. | 1 | 500.0 | | | 1 | 500.0 | 1 | 500.0 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлан дах биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг Үндсэн хөрөнгийн тайлангийн худалдан авсан хөрөнгийг тулган баталгаажуулахад 692,622,244.69 төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна. | 1 | 692,622.2 | | | 1 | 692,622.2 | 1 | 692,622.2 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд Гэрэл, цахилгааны зардлыг 1,337,379.85 төгрөгөөр дутуу, Түлш халаалтын зардлыг 864,387.62 төгрөгөөр илүү, Цэвэр, бохир усны зардлыг 39,997.00 төгрөгөөр дутуу, Бичиг хэргийн зардлыг 1,299,100.00 төгрөгөөр илүү, Тээвэр, шатахууны зардлыг 282,103,190.43 төгрөгөөр илүү, Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгалын зардлыг 1,285,284.00 төгрөгөөр илүү, Томилолт, зочны зардлыг 56,000.00 төгрөгөөр илүү, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 649,844,227.48 төгрөгөөр дутуу, Бараа үйлчилгээний бусад зардлыг 13,921,700.00 төгрөгөөр дутуу, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 1,880,600.00 төгрөгөөр дутуу, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардал 6,286,000.00 | 1 | 959,917.8 | | | 1 | 959,917.8 | 1 | 959,917.8 | | | | |

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|---|----------|--------------------|--|--|----------|--------------------|----------|--------------------|--|--|--|--|
| төгрөгөөр дутуу, Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 1,000,000.00 төгрөгөөр илүү тус тус илэрхийлсэн байна. | | | | | | | | | | | | |
| Санхүүгийн тодруулгын өглөгийн тайланд Цалингийн өглөгийг 17,353,246.00 төгрөг, гэрэл цахилгааны өглөгийг 2,664,643.19 төгрөг, Түлш халаалтын өглөгийг 3,590,697.00 төгрөг, Шуудан холбооны өглөгийг 1,717,850.00 төгрөг, Цэвэр, бохир усны өглөгийг 400,953.00 төгрөг, Тээвэр шатахууны өглөгийг 4,514,300.00 төгрөг, Албан томилолтын өглөгийг 3,924,000.00 төгрөг, Урсгал засварын өглөгийг 28,436,600.00 төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасан байна. | 1 | 62,602.2 | | | 1 | 62,602.2 | 1 | 62,602.2 | | | | |
| Дүн | 6 | 2,338,556.2 | | | 6 | 2,338,556.2 | 6 | 2,338,556.2 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|----------|---------------|---------|-----------------|----------|---------|------|--------------------------------------|---------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | А/т/тоо | Тоо | Дүн |
| Засаг Даргын Тамгын газрын даргын 2024 оны А/01 дугаар тушаалын албан хаагчдын цалин, нэмэгдлийн хэмжээ хүний нөөцийн мэдээлэлтэй зөрүүтэй, төсөв захирагч өөрт олгогдсон бүрэн эрхийг үндэслэж тушаал гаргаагүй байна. | 1 | 0.00 | | | | | 1 | 0.00 | | | | |
| Хагас, бүтэн жилээр 11,366,510,274.97 төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байгаа нь төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хяналт алдагдсан байх эрсдэлийг үүсгэсэн байна. | 1 | 0.00 | | | 1 | 0.00 | | | | | | |
| Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг НХМаягт БМ-8 маягт, бараа материалын тайланг НХМаягт БМ-9 маягтаар хөтлөөгүй, шаардах хуудас бөглөөгүй, 587,121,605.90 төгрөгийн бараа материалыг тооллогоор баталгаажуулаагүй, үлдэгдлээр тайлагнан эргэлтийн хөрөнгө дутагдах эрсдэлийг үүсгэсэн байна | 1 | 0.00 | | | | | 1 | 0.00 | | | | |
| Он дамжсан 24,296,300.00 төгрөгийн өвсний авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, мөн барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна. | 1 | 24,296.3 | | | 1 | 24,296.3 | | | | | | |
| Бичиг хэргийн эрхлэгч нь ээлжийн амралтын цалингаа 8 сард тооцуулан авсан боловч Архив бичиг хэргийн эрхлэгчийг ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй үндэслэлээр 1,815,000 төгрөгийг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох захирамж гараагүй байхад 1 албан хаагчид 430,000 төгрөгийн зэрэг дэв олгосон байна. | 1 | 2,245.0 | 1 | 2,245.0 | | | | | | | | |
| Албан хаагчдын алба хаасан хугацааны нэмэгдэл, зэргийн нэмэгдлийг түүвэрлэн шалгахад хувь хэмжээ сар бүр өөрчилж олгосон байна. | 1 | 0.00 | | | 1 | 0.00 | | | | | | |
| Нягтлан бодогчтой байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 100%-иар тооцож 9,093,454,54 төгрөгийн нэмэгдэл олгосон байна | 1 | 9,093.4 | | | 1 | 9,093.4 | | | | | | |

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|--|---|----------|---|---------|----------|--|--|--|--|--|--|--|
| Нягтлан бодогчид онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй албан хаасан хугацааны нэмэгдэлд 1,363,911.82 төгрөгийн эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй олгосон байна | 1 | 1,363.9 | 1 | 1,363.9 | | | | | | | | |
| Шинэ жилийн баярыг тохиолдуулан байгууллагын ажилтнуудын хүүхдүүдэд 900,000 төгрөгийн бэлэг өгсөн байна. | 1 | 900.0 | | 1 | 900.0 | | | | | | | |
| Шатахууны зарцуулалтыг түүвэрлэн шалгахад хувийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг албан хэрэгцээнд унахдаа жолоочийн тооцооны хуудсыг дутуу бөглөсөн,спидометрийн заалт бичээгүй, шаардах хуудсыг бүрэн бөглөөгүй, шатахууны норм, норматив тооцоогүй, авто машин унах эрхгүй албан тушаалтнуудад хяналтгүй тээврийн хэрэгсэл ашиглаж, шатахуун зарцуулсан байна. | 1 | 56,174.4 | | 1 | 56,174.4 | | | | | | | |
| бараа, 70,000.00 төгрөгөөр бууз, хуушуур, 113,000.00 төгрөгөөр тахианы махтай пицца, хонины махтай бууз, 380,000.00 төгрөгийн принтер, 650,000.00 төгрөгийн сандал, Багаж, техник хэрэгсэл /210601/ зардлаас 135,000.00 төгрөгийн суурин утасны төлбөр, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх /210902/ зардлаас 385,500.00 төгрөгийн 100 жилийн ойн арга хэмжээний хамт олны зураг, Шуудан, холбоо, интернэт /210403/ зардлаас 300,000.00 төгрөгийн нэгж худалдан авч төсвийн хөрөнгийг зарцуулсан байна | 1 | 4,891.6 | | 1 | 4,891.6 | | | | | | | |
| Тайланг хугацаанд 1203-ӨМЭ улсын дугаартай Ланд-200 тээврийн хэрэгсэлд 5,516,500.00 төгрөг, 6177-ӨМА улсын дугаартай пургонд 4,649,900.00 төгрөгөөр урсгал засвар хийхдээ техник ашиглалтын паспорт хөтлөөгүй байна. | 1 | 0.00 | | 1 | 0.00 | | | | | | | |
| Засаг даргын Тамгын газрын багийн дарга нарын хувийн эзэмшлийн 1142-ӨМЭ дугаартай Pruis-30 маркийн авто тээврийн хэрэгсэлд 485,000.00 төгрөгийн урсгал засвар, 2272-ӨМӨ улсы дугаартай Pruis-30 маркийн хувийн хэрэгцээний авто тээврийн хэрэгсэлд 680,900.00 төгрөгийн урсгал засвар, 7225-ӨМӨ улсын дугаартай Recton маркийн авто тээврийн хэрэгсэлд 286,000.00 төгрөгийн аккумулятор, 5043-ӨМЭ улсын дугаартай Toyota Sai маркийн авто тээврийн хэрэгсэлд 560,000.00 төгрөгөөр тус тус урсгал засвар хийж төсвийн хөрөнгийг зарцуулсан байна. | 1 | 2,011.9 | | 1 | 2,011.9 | | | | | | | |
| Баг, хорооны үйл ажиллагааны /210801/ зардлаас Багийн иргэдийн нийтийн хурлаар багийн төвийг цэвэрлэх, гадна талбайн хог цэвэрлэх, шатаах зэрэг ажлыг хариуцаж ажиллуулахаар 4 багийн иргэнтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан улиралд 660,000.00 төгрөгөөр ажлын хөлсийг тооцож олгосон боловч гүйцэтгэсэн ажил нь баримтаар нотлогдохгүй төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. | 1 | 10,560.0 | | 1 | 10,560.0 | | | | | | | |

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|--|-----------|------------------|----------|----------------|-----------|------------------|----------|-----------------|--|--|--|--|
| Ажлын байрны албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан зорилттой давхардуулан Засаг даргын Тамгын газрын няравтай "Сумын төвийн ногоон байгууламж усалж арчлах" ажлын гэрээ байгуулан 1,100,000 төгрөг олгосон байна. | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | | | | | | |
| "Ёл мухар шивэртийн амны мөс нэмэгдүүлэх арга хэмжээний ажил"-ыг 5,000,000 төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч хийсэн ажлын тайлан байхгүй, гэрээнд хийх ажлыг тодорхой тусгаагүй байна | 1 | 5,000.0 | | | 1 | 5,000.0 | | | | | | |
| Тус байгууллагад бүртгэлтэй 1203-ӨМЭ улсын дугаартай 84,000,000 төгрөгийн дансны үнэтэй Ланд-200 маркийн тээврийн хэрэгслийг 2024 оны 08 сард үерт автуулсан гэх шалтгаанаар ашиглах боломжгүй байгаад мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй байна. | 1 | 84,000.0 | | | 1 | 84,000.0 | | | | | | |
| Ханхонгор сумын 100 жилийн ойн бэлтгэл арга хэмжээнд 5 болон 6 ханатай гэр нийлүүлэх ажлын Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулаагүй, баримт бичгийн бүрдэл дутуу, цахим системд нийтлээгүй байна. | 1 | 0.00 | | | 1 | 0.00 | | | | | | |
| ДҮН | 18 | 201,536.6 | 2 | 3,608.9 | 12 | 108,927.7 | 4 | 89,000.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны хуультай холбоотой зөрчил гараагүй байна. | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил гараагүй байна. | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |